**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Онцгой байдлын ерөнхий газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: СНАГ-2024/13/НА-СТА-ТТЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2024 он | Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд<br>Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Энхдалай<br>Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Долгоржав<br>Утас: 261740 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/мянган төгрөгөөр/*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 198,759,804.1 | 193,580,648.2 |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 1,530,079.3 | 493,590.8 |
| **33** | **АВЛАГА** | 22,280,856.0 | 20,659,337.7 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 8,831,472.6 | 1,816,397.7 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 73,295,016.0 | 82,005,515.8 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 72,827,527.0 | 79,530,958.9 |
| **360** | **БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | 19,994,853.2 | 9,074,847.3 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 298,746,972.3 | 342,754,296.2 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 298,746,972.3 | 342,754,296.2 |
| **39200** | **Биет хөрөнгө** | 267,518,898.0 | 310,704,141.3 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | 31,228,074.3 | 32,050,154.8 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **497,506,776.5** | **536,334,944.3** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 4,358,224.9 | 4,916,136.8 |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 4,358,224.9 | 4,916,136.8 |
| **41200** | **Богино хугацаат зээлийн өглөг** | 132,038.3 | 103,702.8 |
| **41300** | **Өглөг** | 4,225,186.6 | 4,811,934.0 |
| **41400** | **Урьдчилж орсон орлого** | 1,000.0 | 500.0 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 493,148,551.5 | 531,418,807.6 |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 493,148,551.5 | 531,418,807.6 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 95,807,699.3 | 96,977,413.7 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | 347,475,909.1 | 386,343,527.9 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 49,864,943.2 | 48,097,866.0 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **497,506,776.5** | **536,334,944.3** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/мянган төгрөгөөр/*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **267,563,787.5** | **260,256,572.9** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **71,451,585.4** | **59,299,190.8** |
| **120** | Нийтлэг татварын бус орлого | 71,369,572.6 | 59,299,190.8 |
| **122** | Тусламжийн орлого | 82,012.8 | 0.0 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **196,112,202.1** | **200,957,382.1** |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **171,427,487.2** | **205,613,131.4** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **171,427,487.2** | **205,495,284.0** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **157,269,195.0** | **187,091,841.5** |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 70,788,804.4 | 94,508,676.4 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 2,226,182.2 | 2,797,097.6 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5,484,511.4 | 6,863,165.3 |
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | 7,373,489.0 | 7,188,923.6 |
| **2105** | Нормативт зардал | 9,231,823.5 | 9,535,125.9 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,406,476.4 | 5,865,750.0 |
| **2107** | Томилолт, зочны зардал | 1,227,059.5 | 1,105,106.5 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,751,128.4 | 18,023,979.3 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 46,779,720.5 | 41,204,016.9 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **14,158,292.2** | **18,403,442.4** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0.0** | **117,847.5** |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН** | **96,136,300.3** | **54,643,441.5** |
| **IV** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 0.0 | 42,496.4 |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 10,234,894.9 | 17,019,223.1 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН** | **85,901,405.4** | **37,666,714.7** |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/мянган төгрөгөөр/*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **205,786,850.8** | **213,316,054.4** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **8,850,844.9** | **7,194,771.1** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 8,850,844.9 | 7,194,771.1 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **196,936,006.0** | **206,121,283.3** |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **177,381,417.8** | **191,544,815.7** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **177,381,417.8** | **191,544,815.7** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 158,643,015.1 | 165,060,947.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 70,202,320.6 | 93,761,090.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 2,270,351.4 | 2,848,445.9 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5,565,974.9 | 6,758,032.6 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,246,726.4 | 5,823,675.2 |
| 2105 | Нормативт зардал | 9,261,251.1 | 6,020,358.7 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,629,887.4 | 4,972,617.3 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,183,139.5 | 1,096,276.5 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 11,724,778.9 | 18,807,560.9 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 45,558,585.0 | 24,972,890.7 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 18,738,402.6 | 26,483,867.8 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **28,405,433.1** | **21,771,238.8** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **27,215,545.6** | **22,807,727.3** |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 27,215,545.6 | 22,807,727.3 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 27,215,545.6 | 22,807,727.3 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(27,215,545.6)** | **(22,807,727.3)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **1,189,887.4** | **(1,036,488.6)** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 340,191.9 | 1,530,079.3 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,530,079.3 | 493,590.8 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

*Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/мянган төгрөгөөр/*

| Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **406,317,979.2** | **0.0** | **406,317,979.2** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 257,140.1 | 0.0 | 257,140.1 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 406,575,119.3 | 0.0 | 406,575,119.3 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (220,402.9) | 0.0 | (220,402.9) |
| Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 892,429.7 | 0.0 | 892,429.7 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.0 | 0.0 | 0.0 |
| Өмчид гарсан өөрчлөлт | 0.0 | 0.0 | 0.0 |
| Зарласан ногдол ашиг | 0.0 | 0.0 | 0.0 |
| Тайлант үеийн үр дүн | 85,901,405.4 | 0.0 | 85,901,405.4 |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **493,148,551.5** | **0.0** | **493,148,551.5** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 1,200,904.1 | 0.0 | 1,200,904.1 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 494,349,455.7 | 0.0 | 494,349,455.7 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (1,767,059.4) | 0.0 | (1,767,059.4) |
| Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 1,169,714.4 | 0.0 | 1,169,714.4 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.0 | 0.0 | 0.0 |
| Өмчид гарсан өөрчилөлт | 0.0 | 0.0 | 0.0 |
| Зарласан ногдол ашиг | 0.0 | 0.0 | 0.0 |
| Тайлант үеийн үр дүн | 37,666,714.7 | 0.0 | 37,666,714.7 |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **531,418,807.6** | **0.0** | **531,418,807.6** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | **181,309,767,500.00** | **180,864,872,641.13** | **444,894,858.87** | **99.8** |
| **21** | УРСГАЛ ЗАРДАЛ | **156,386,223,600.00** | **155,990,362,869.13** | **395,860,730.87** | **99.7** |
| **210** | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | **139,306,581,700.00** | **138,934,606,684.13** | **371,975,015.87** | **99.7** |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | **93,233,893,100.00** | **93,151,414,220.41** | **82,478,879.59** | **99.9** |
| 210101 | Үндсэн цалин | 44,560,674,300.00 | 46,089,362,792.98 | (1,528,688,492.98) | 103.4 |
| 210102 | Нэмэгдэл | 45,635,590,700.00 | 44,058,156,193.37 | 1,577,434,506.63 | 96.5 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,590,134,300.00 | 1,614,525,470.50 | (24,391,170.50) | 101.5 |
| 210104 | Урамшуулал | 1,447,493,800.00 | 1,389,369,763.56 | 58,124,036.44 | 96.0 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | **2,856,992,400.00** | **2,776,077,613.60** | 80,914,786.40 | 97.2 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 481,442,900.00 | 458,123,965.83 | 23,318,934.17 | 95.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 56,639,700.00 | 55,451,485.26 | 1,188,214.74 | 97.9 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 45,313,900.00 | 42,997,994.95 | 2,315,905.05 | 94.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 11,327,700.00 | 10,645,879.04 | 681,820.96 | **94.0** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,262,268,200.00 | 2,208,858,288.52 | **53,409,911.48** | 97.6 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | **6,807,999,900.00** | **6,672,246,964.51** | 135,752,935.49 | 98.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,694,674,100.00 | 1,531,020,674.31 | 163,653,425.69 | 90.3 |
| 210302 | Түлш, халаалт | 4,287,253,100.00 | 4,360,687,508.17 | (73,434,408.17) | 101.7 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 376,779,400.00 | 331,657,905.40 | 45,121,494.60 | **88.0** |
| 210304 | Байрны түрээс | 449,293,300.00 | 448,880,876.63 | **412,423.37** | 99.9 |
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | **4,562,300,600.00** | **4,558,710,880.61** | 3,589,719.39 | 99.9 |
| 210401 | Бичиг хэрэг | 115,493,500.00 | 115,516,036.00 | (22,536.00) | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,698,829,900.00 | 3,698,819,195.28 | 10,704.72 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 114,249,700.00 | 111,867,329.30 | 2,382,370.70 | **97.9** |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 26,039,200.00 | 25,775,293.50 | **263,906.50** | 99.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 607,688,300.00 | 606,733,026.53 | 955,273.47 | 99.8 |
| **2105** | Нормативт зардал | **5,885,969,100.00** | **5,883,186,488.39** | 2,782,611.61 | **100.0** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 69,799,200.00 | 69,783,215.27 | 15,984.73 | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 3,071,637,200.00 | 3,069,376,472.12 | **2,260,727.88** | 99.9 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,744,532,700.00 | 2,744,026,801.00 | 505,899.00 | 100.0 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | **5,819,519,900.00** | **5,818,622,504.96** | 897,395.04 | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 304,877,900.00 | 304,868,609.16 | 9,290.84 | **100.0** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 23,991,100.00 | 23,944,100.00 | 47,000.00 | 99.8 |
| 210604 | Урсгал засвар | 5,490,650,900.00 | 5,489,809,795.80 | **841,104.20** | 100.0 |
| **2107** | Томилолт, зочны зардал | **130,802,500.00** | **130,769,742.00** | 32,758.00 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 130,802,500.00 | 130,769,742.00 | 32,758.00 | 100.0 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | **19,590,813,100.00** | **19,529,486,127.61** | 61,326,972.39 | 99.7 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,893,023,100.00 | 15,876,163,827.56 | 16,859,272.44 | 99.9 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 9,860,300.00 | 8,999,200.00 | 861,100.00 | **91.3** |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,172,502,800.00 | 3,172,239,031.43 | 263768.57 | **100.0** |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 83,481,900.00 | 73,466,611.64 | **10,015,288.36** | **88.0** |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 28,219,300.00 | 25,317,800.00 | 2,901,500.00 | 89.7 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 149,170,800.00 | 146,415,813.46 | 2,754,986.54 | 98.2 |
| 210807 | Газрын төлбөр | 254,477,100.00 | 226,883,843.52 | **27,593,256.48** | 89.2 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 77,800.00 | 0 | **77,800.00** | 0.0 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | **418,291,100.00** | **414,092,142.04** | **4,198,957.96** | **99.0** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 99,135,200.00 | 96,345,738.04 | 2,789,461.96 | **97.2** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 319,155,900.00 | 317,746,404.00 | 1,409,496.00 | **99.6** |
| **213** | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | **17,079,641,900.00** | **17,055,756,185.00** | 23,885,715.00 | **99.9** |
| **2131** | Засгийн газрын урсгал шилжүүлэг | **192,760,000.00** | **192,755,909.00** | 4091 | **100.0** |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 192,760,000.00 | 192,755,909.00 | **4,091.00** | **100.0** |
| **2132** | Бусад урсгал шилжүүлэг | **16,886,881,900.00** | **16,863,000,276.00** | **23,881,624.00** | **99.9** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 8,772,054,600.00 | 8,770,585,085.00 | **1,469,515.00** | **100.0** |
| 213205 | Төреес иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 4,410,900.00 | 4,410,900.00 | **0.00** | **100.0** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 7,414,946,000.00 | 7,393,889,077.00 | **21,056,923.00** | **99.7** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 695,470,400.00 | 694,115,214.00 | **1,355,186.00** | **99.8** |
| **22** | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | **24,923,543,900.00** | **24,874,509,772.00** | **49,034,128.00** | **99.8** |
| 220001 | Барилга байгууламж | 7,543,801,700.00 | 7,495,156,124.00 | **48,645,576.00** | **99.4** |
| 223001 | Бусад хөрөнгө | 8,500,000,000.00 | 8,500,000,000.00 | **0.00** | **100.0** |
| 224001 | Стратегийн нөөц хөрөнгө | 8,879,742,200.00 | 8,879,353,648.00 | **388,552.00** | **100.0** |
| **III** | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | **181,309,767,500.00** | **180,892,837,451.24** | **416,930,048.76** | **99.8** |
| **31** | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | **174,784,499,700.00** | **174,099,276,745.92** | **685,222,954.08** | **99.6** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 174,784,499,700.00 | 174,099,276,745.92 | **685,222,954.08** | **99.6** |
| **35** | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | **6,525,267,800.00** | **6,793,560,705.32** | **(268,292,905.32)** | **104.1** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,525,267,800.00 | 6,793,270,900.32 | **(268,003,100.32)** | **104.1** |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

*Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*
*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **40,549,962,258.85** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **39,562,312,436.11** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **30,554,997,984.98** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | **609,675,771.64** |
| 210101 | Үндсэн цалин | | 98,100,000.00 |
| 210102 | Нэмэгдэл | | 57,150,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 454,425,771.64 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | **72,368,278.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 61,366,403.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 11,001,875.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | **85,785,611.12** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 56,249,241.00 |
| 210302 | Түлш, халаалт | | 19,343,438.57 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 10,192,931.55 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **1,282,437,683.54** |
| 210401 | Бичиг хэрэг | | 75,972,030.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 1,056,041,189.02 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 6,900,239.30 |
| 210404 | Ном, хэвлэл | | 17,801,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 21,161,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 104,561,425.22 |
| **2105** | **Нормативт зардал** | | **1,049,648,156.09** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 15,445,383.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 627,319,773.09 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 406,883,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **1,250,400,329.05** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 377,226,242.00 |
| 210602 | Тавилга | | 3,828,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 10,330,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 859,016,087.05 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **965,506,781.00** |
| 210701 | Гадаад албан томилолт | | 32,318,922.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 933,187,859.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **1,589,149,842.41** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 1,582,471,387.98 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 2,490,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | 2,792,854.43 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | 491,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 848,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **23,650,025,532.13** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 23,328,217,812.13 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 321,807,720.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **9,007,314,451.13** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | **821,097,428.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох  бусад тэтгэмж, урамшуулал | | 80,475,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 740,622,428.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **8,186,217,023.13** |

| | | | |
|---|---|---|---|
| 213305 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт,нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 8,186,217,023.13 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **987,649,822.74** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | | **987,649,822.74** |
| 221001 | Их засвар | | 94,000,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | | 304,050,000.00 |
| 224001 | Стратегийн нөөц хөрөнгө | | 36,873,596.74 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 552,726,226.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **40,549,657,387.85** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **40,549,657,387.85** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 1,316,966,680.40 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 20,728,718,983.15 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 5,281,172,086.80 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 13,222,799,637.50 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | **(304,871.00)** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 304,871.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 0.00 |

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Онцгой байдлын ерөнхий газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 44 байгууллага, 1 зардлын тайлангууд нэгтгэгдсэнээс 29 шалгагдагч байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 1 шалгагдагч байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” /*Онцгой байдлын ерөнхий газрын аппарат*/ санал дүгнэлт өгч, 15 байгууллага, сан, зардлын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 29, “*Хязгаарлалттай*” 1 *(Онцгой байдлын ерөнхий газрын төсвийн шууд захирагч)* дүгнэлт өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 23,380.8 сая төгрөгийн 40 алдааг залруулж, нийт 2,807.5 сая төгрөгийн 85 зөрчил илэрснээс 12.1 сая төгрөгийн зөрчилд 11 төлбөрийн акт тогтоож, 2,251.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 31 албан шаардлага хүргүүлж, 544.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 43 зөвлөмж өгсөн.

Төвлөрүүлэн захирагчийн аудитаар илэрсэн 2,807.5 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 1,714.3 сая төгрөгөөс өндөр тул **Хязгаарлалттай** дүгнэлт өгсөн.

### 1. Төсвийн төвлөрүүлэн захирагч

### 1.1 Албан шаардлага

*1.* ***Илрүүлэлт:*** Тайлант оны эцэст өглөг өмнөх оны үлдэгдлээс 557.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.1 “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
***Шийдвэрлэсэн нь:*** Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн;

*2.* ***Илрүүлэлт:*** Онцгой байдлын байгууллагын “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь хууль тогтоомж, салбарын болон аврах ажиллагааны зориулалтын тоног төхөөрөмж, бараа материалын бүртгэлийн онцлог, стандартын өөрчлөлтүүдийг тусгаагүй, шинэчлэх ажил удаашралтай байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.", 20 зүйлийн 20.2.2 "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй.
***Шийдвэрлэсэн нь:*** Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн;

3.***Илрүүлэлт:*** Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 44 байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 145 алдаа, зөрчил илэрснээс санхүүгийн тайлантай холбоотой 23,091.3 сая төгрөгийн 38 алдаа, 2,249.7 сая төгрөгийн 82 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 3,978.7 сая төгрөгийн 25 зөрчил илэрсэн, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-т "хариуцлагатай байх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасныг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.
***Шийдвэрлэсэн нь:*** Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн;

### 1.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой***

Онцгой байдлын байгууллагын хэмжээнд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийн 96-98 хувь нь бусад тээврийн хэрэгслээс ялгарах тод өнгийн дэвсгэртэй улсын дугаараар өөрчлөөгүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Төрийн болон орон нутгийн өмчит бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ”, Авто тээврийн хэрэгслийн улсын дугаар тэмдэгтийн MNS4410-1:2002 стандарттай нийцэхгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** *Салбарын тээврийн хэрэгслүүдийн улсын дугаарыг бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солих арга хэмжээ авч ажиллах.*

***2.Санхүүгийн тайлагналтай холбоотой***

Нэмэлт санхүүжилтийн данстай боловч үндсэн үйл ажиллагааны харилцах дансаар “маш нууц, нууц”-ын зэрэглэлийн шийдвэртэй хөрөнгийн ажил гүйлгээ энгийн ажил гүйлгээтэй хамт хийгдэж байгаа нь холбогдох хууль, дүрэм журамд нийцэхгүй байна. Энэ нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 "эрхэлсэн салбар, харьяа байгууллагын хэмжээнд байгаа төрийн болон албаны нууцын хамгаалалтад хяналт тавих;", 13 дугаар зүйлийн 13.1.4.к.гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын тусгай архивын данс, бүртгэл, эд зүйл; Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам"-ын 7-д “Нэмэлт төсвийн зарцуулалтын эрх олгох” 7.1. "Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийг төсвийн байгууллага тусгай дансаар дамжуулан эдийн засгийн ангиллаар зарцуулна." заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** *Үндсэн үйл ажиллагааны харилцах дансаар хийгдэж байгаа маш нууц, нууц зэрэглэлийн шийдвэртэй ажил гүйлгээг тусгай дансаар хийх арга хэмжээ авч ажиллах.*

### 5.1 Харьяа байгууллагууд

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн үе шатны аудитаар илэрсэн нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 289.5 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 656.3 сая төгрөгийн 7 зөрчил илрүүлснээс, 347.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлж, 308.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг өгсөн.

#### 5.1.1 Албан шаардлага

*1.* ***Илрүүлэлт:*** Жаргалант сэргээн засах төв 113 дугаар анги нь тайлант оны эцэст авлага 85.1 сая төгрөг, өглөг 0.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.1 “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

*2.* ***Илрүүлэлт:*** Улсын нөөцийн 185 дугаар анги нь Засгийн газрын 2018 оны 364 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу нөөцөөс борлуулан сэлгэхээр техник, хэрэгсэл, бараа чөлөөлөгдсөн бөгөөд 262.5 сая төгрөгийн үлдэгдэл барааг борлуулах явц болон тогтоолын хэрэгжилт удаашралтай байна. Энэ нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйл ”Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх, 28.1.3. "гамшгийн нөөцийг зохих журмын дагуу захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэлтэд хяналт тавих;", 28.1.4. "гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах нэмэлт зардлыг Засгийн газрын нөөц хөрөнгөөс, бараа, материал, тоног төхөөрөмжийг улсын нөөцөөс гаргах асуудлыг Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх;" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

#### 5.1.2 Зөвлөмж

***1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой***

Агаараас эрэн хайх, аврах 111 дүгээр анги нь албан үүргээ гүйцэтгэж буй албан ажлын байр, нисдэг тэрэгний тавиуланг үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй байна. Энэ нь Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Иргэн, хуулийн этгээд Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 8.1.1-д заасан эрхийг хуульд заасан журмын дагуу эрхийн улсын

бүртгэлд бүртгүүлснээр өмчлөх эрх үүснэ”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-т "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4. "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:", 14.4.2."бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** *Хөрөнгийн үнэлгээг тодорхойлж, холбогдох байгууллагат хандаж шийдвэр гаргуулан үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгах.*

Ар талын 115 дугаар ангид бүртгэлтэй тээврийн хэрэгслүүд нь бусад тээврийн хэрэгслээс ялгарах тод өнгийн дэвсгэрээр өөрчлөөгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Төрийн болон орон нутгийн өмчит бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ”, заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** *Тээврийн хэрэгслүүдийн улсын дугаарыг бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солих арга хэмжээ авч ажиллах.*

Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв 119 дүгээр анги Ангийн захирагчийн 2023 оны А/7 дугаар тушаалаар жилийн эцэст эд хөрөнгийн тооллогыг гүйцэтгэсэн боловч илтгэх хуудасгүй байна. *Энэ нь* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл “Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйл. Тооллогын комисс, түүний эрх, үүрэг, 4. Тооллогын комисс дараах үүрэгтэй, 1/ эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах; 2/ тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** *Үндсэн хөрөнгийн тооллогыг үр дүнтэй гүйцэтгэх, бүртгэлийг журам зааврын дагуу бэлтгэж, үр дүнг илтгэх хуудас, тайлангаар баримтжуулж байх.*

Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв 119 дүгээр ангид бүртгэлтэй тээврийн хэрэгслийн гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлээгүй, улсын дугаарын дэвсгэр бусад тээврийн хэрэгслээс ялгарах тод өнгийн дэвсгэрээр өөрчлөөгүй байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Иргэн, хуулийн этгээд Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 8.1.1-д заасан эрхийг хуульд заасан журмын дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлснээр өмчлөх эрх үүснэ”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-т "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** *Төсвийн захирагчийн нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслийн эзэмших эрхийн гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлэн бүртгүүлэх, тээврийн хэрэгслүүдийн улсын дугаарыг бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солих арга хэмжээ авч ажиллах*

***2.Бараа материалын данстай холбоотой***

Жаргалант сэргээн засах төв 113 дугаар анги нь Улсын комисс хүлээн авсан эсэх нь тодорхойгүй, Хот байгуулалт, хөгжлийн газрын Барилгын чанар аюулгүй байдлын хяналтын хэлтсийн 2021 оны дүгнэлтээр норм дүрмийн шаардлага хангахгүй болсон, ашиглах боломжгүй, балансын үнэ 234.9 сая төгрөгийн үнэтэй зоогийн газрын барилга бүртгэлтэй байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Иргэн, хуулийн этгээд Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 8.1.1-д заасан эрхийг хуульд заасан журмын дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлснээр өмчлөх эрх үүснэ”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1.2 Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ. заалтыг хэрэгжүүлээгүй санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** *Ашиглах боломжгүй, чанарын шаардлага хангахгүй барилга байгууламжийг талаар холбогдох эрх бүхий байгууллагат хандаж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;*

Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв 119 дүгээр анги нь Албан хаагчдын хувцсыг бэлэн бүтээгдэхүүний дансанд буруу ангилан бүртгэсэн байна. Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-т "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4. "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:", 14.4.2."бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** *Цаашид албан хаагчдын хувцсыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, журам зааврын дагуу зөв ангилан бүртгэж тайлагнаж байх;*

## Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа

Аудитаар нийт 23,380.8 сая төгрөгийн алдаа 40 илэрснээс аудитын явцад 23,380.8 сая төгрөгийн алдааг залруулсан.

### Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | | Үүнээс Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Төсвийн шууд захирагч** | | | | | | | | | | | | | |
| 1 | ОБЕГ - аппарат | 1 | 1,156,350.6 | | | 1 | 1,156,350.6 | 1 | 1,156,350.6 | | | | |
| 2 | Үндэсний аврах бригад | 1 | 82,004.7 | | | 1 | 82,004.7 | 1 | 82,004.7 | | | | |
| 3 | Шатахууны нөөцийн 112 дугаар анги | 1 | 139,500.0 | | | 1 | 139,500.0 | 1 | 139,500.0 | | | | |
| 4 | Хүнсний нөөцийн 179 дүгээр анги | 1 | 150,000.0 | | | 1 | 150,000.0 | 1 | 150,000.0 | | | | |
| 5 | Нийслэлийн онцгой байдлын газар | 1 | 11,042.1 | | | 1 | 11,042.1 | 1 | 11,042.1 | | | | |
| 6 | Баянгол дүүргийн ОБХ | 3 | 1,023,138.3 | | | 3 | 1,023,138.3 | 3 | 1,023,138.3 | | | | |
| 7 | Баянзүрх дүүргийн ОБХ | 3 | 15,501.0 | | | 3 | 15,501.0 | 3 | 15,501.0 | | | | |
| 8 | Сонгинохайрхан дүүргийн ОБХ | 3 | 86,102.7 | | | 3 | 86,102.7 | 3 | 86,102.7 | | | | |
| 9 | Чингэлтэй дүүргийн ОБХ | 1 | 1,006,710.0 | | | 1 | 1,006,710.0 | 1 | 1,006,710.0 | | | | |
| 10 | Хан-Уул дүүргийн ОБХ | 1 | 6,656.0 | | | 1 | 6,656.0 | 1 | 6,656.0 | | | | |
| 11 | Архангай аймгийн ОБГ | 1 | 4,574.2 | | | 1 | 4,574.2 | 1 | 4,574.2 | | | | |
| 12 | Баян-Өлгий аймгийн ОБГ | 1 | 784,136.6 | | | 1 | 784,136.6 | 1 | 784,136.6 | | | | |
| 13 | Баянхонгор аймгийн ОБГ | 2 | 5,072.1 | 1 | 490.4 | 1 | 4,581.7 | 2 | 5,072.1 | | | | |
| 14 | Булган аймгийн ОБГ | 2 | 394,696.3 | 1 | 28,575.7 | 1 | 366,120.6 | 2 | 394,696.3 | | | | |
| 15 | Говь-Алтай аймгийн ОБГ | 1 | 37,748.0 | 1 | 37,748.0 | | | 1 | 37,748.0 | | | | |
| 16 | Говьсүмбэр аймгийн ОБГ | 1 | 4,180.0 | | | 1 | 4,180.0 | 1 | 4,180.0 | | | | |
| 17 | Дархан-Уул аймгийн ОБГ | 2 | 16,845,184.0 | | | 2 | 16,845,184.0 | 2 | 16,845,184.0 | | | | |
| 18 | Дундговь аймгийн ОБГ | 1 | 35,105.3 | | | 1 | 35,105.3 | 1 | 35,105.3 | | | | |
| 19 | Өмнөговь аймгийн ОБГ | 3 | 168,491.9 | | | 3 | 168,491.9 | 3 | 168,491.9 | | | | |
| 20 | Сэлэнгэ аймгийн ОБГ | 1 | 650,630.7 | 1 | 650,630.7 | | | 1 | 650,630.7 | | | | |
| 21 | Төв аймгийн ОБГ | 6 | 97,440.7 | | | 6 | 97,440.7 | 6 | 97,440.7 | | | | |
| 21 | Ховд аймгийн ОБГ | 1 | 674,430.0 | | | 1 | 674,430.0 | 1 | 674,430.0 | | | | |
| 22 | Хэнтий аймгийн ОБГ | 1 | 2,100.0 | | | 1 | 2,100.0 | 1 | 2,100.0 | | | | |
| **Нийт дүн** | | **40** | **23,380,795.2** | **4** | **717,444.8** | **36** | **23,380,795.2** | **40** | **23,380,795.2** | | | | |

Аудитаар нийт 2,807.5 сая төгрөгийн зөрчил1 илэрснээс, 12.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2,251.4 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 544.0 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Д/д | Шалгагдагч байгууллагын нэр | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцох албан тушаалтан | | Хууль хяналтын байгууллагад шилүүлэх асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | ОБЕГ - ТТЗ | 5 | 557,900.0 | | | 3 | 557,900.0 | 2 | 0.0 | | | | |
| | **Нийт** | **5** | **557,900.0** | | | **3** | **557,900.0** | **2** | **0.0** | | | | |
| 1 | ОБЕГ - аппарат | 3 | 1,039,265.6 | | | 3 | 1,039,265.6 | | | | | | |
| 3 | Үндэсний аврах бригад | 7 | 58,869.8 | 1 | 2,166.7 | 1 | 0.0 | 5 | 56,703.1 | | | | |
| 4 | Агаараас эрэн хайх 111 дүгээр анги | 1 | - | | | | | 1 | 0.0 | | | | |
| 5 | Жаргалант сэргээн заслын төв 113 дугаар анги | 2 | 320,299.5 | | | 1 | 85,384.0 | 1 | 234,915.5 | | | | |
| 6 | Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төв 119 дугаар анги | 3 | 73,494.0 | | | | | 3 | 73,494.0 | | | | |
| 7 | Улсын нөөцийн 185 дугаар анги | 1 | 262,527.7 | | | 1 | 262,527.7 | | | | | | |
| 8 | Нийслэлийн онцгой байдлын газар | 2 | 21,958.8 | | | 1 | 12,000.0 | 1 | 9,958.8 | | | | |
| 9 | Багануур дүүргийн ОБХ | 3 | 9,993.1 | | | | | 3 | 9,993.1 | | | | |
| 10 | Багахангай дүүргийн ОБХ | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 | | | | |
| 11 | Баянгол дүүргийн ОБХ | 1 | 3,885.5 | | | | | 1 | 3,885.5 | | | | |
| 12 | Налайх дүүргийн ОБХ | 3 | 14,821.1 | | | | | 3 | 14,821.1 | | | | |
| 13 | Сонгинохайрхан дүүргийн ОБХ | 2 | 7,474.8 | | | | | 2 | 7,474.8 | | | | |
| 14 | Сүхбаатар дүүргийн ОБХ | 1 | 6,415.0 | | | | | 1 | 6,415.0 | | | | |
| 15 | Чингэлтэй дүүргийн ОБХ | 1 | 510.2 | | | | | 1 | 510.2 | | | | |

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | Архангай аймгийн ОБГ | 4 | 5,955.5 | | | 2 | 5,955.5 | 2 | 0.0 | | | | |
| 17 | Баян-Өлгий аймгийн ОБГ | 1 | 18,010.0 | | | | | 1 | 18,010.0 | | | | |
| 18 | Баянхонгор аймгийн ОБГ | 4 | 36,052.2 | 1 | 354.1 | 1 | 4,791.0 | 2 | 30,907.1 | | | | |
| 19 | Булган аймгийн ОБГ | 5 | 31,879.9 | 2 | 1,879.9 | 1 | 0.0 | 2 | 30,000.0 | | | | |
| 20 | Говь-Алтай аймгийн ОБГ | 4 | 17,652.9 | | | 3 | 17,652.9 | 1 | 0.0 | | | | |
| 21 | Говьсүмбэр аймгийн ОБГ | 2 | 11,788.3 | | | | | 2 | 11,788.3 | | | | |
| 22 | Дархан-Уул аймгийн ОБГ | 4 | 9,509.9 | 2 | 2,485.6 | 1 | 0.0 | 1 | 7,024.3 | | | | |
| 23 | Дорнод аймгийн ОБГ | 2 | 138,246.2 | | | 1 | 138,246.2 | 1 | 0.0 | | | | |
| 24 | Дундговь аймгийн ОБГ | 1 | 2,217.1 | 1 | 2,217.1 | | | | | | | | |
| 25 | Завхан аймгийн ОБГ | 3 | 48,588.4 | 1 | 588.4 | 1 | 48,000.0 | 1 | 0.0 | | | | |
| 26 | Орхон аймгийн ОБГ | 4 | 47,846.5 | 2 | 2,180.8 | 2 | 45,665.7 | | | | | | |
| 27 | Өмнөговь аймгийн ОБГ | 5 | 36,198.6 | 1 | 219.2 | 3 | 7,850.0 | 1 | 28,129.4 | | | | |
| 28 | Сэлэнгэ аймгийн ОБГ | 9 | 26,204.9 | | | 6 | 26,204.9 | 3 | 0.0 | | | | |
| 29 | Төв аймгийн ОБГ | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 | | | | |
| | **Нийт** | **80** | **2,249,665.5** | **11** | **12,091.8** | **28** | **1,693,543.5** | **41** | **544,030.2** | | | | |
| **НИЙТ ДҮН** | | **85** | **2,807,565.5** | **11** | **12,091.8** | **31** | **2,251,443.5** | **43** | **544,030.2** | | | | |

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 3,978.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 2,859.6 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 1,119.1 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Д/д | Шалгагдагч байгууллагын нэр | Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийт зөрчил | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | ОБЕГ - аппарат | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 | | |
| 2 | Үндэсний аврах бригад | 1 | 0.0 | | | | | | | 1 | 0.0 |
| 3 | Ар талын 115 дугаар анги | 1 | 0.0 | | | | | | | 1 | 0.0 |
| 4 | Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв | 1 | 0.0 | | | | | | | 1 | 0.0 |
| 5 | Нийслэлийн онцгой байдлын газар | 1 | 0.0 | | | | | | | 1 | 0.0 |
| 6 | Багануур дүүргийн ОБХ | 2 | 14,000.0 | | | | | 1 | 14,000.0 | 1 | 0.0 |
| 7 | Баянгол дүүргийн ОБХ | 1 | 879,985.2 | | | | | | | 1 | 879,985.2 |
| 8 | Баянзүрх дүүргийн ОБХ | 1 | 239,142.1 | | | | | | | 1 | 239,142.1 |
| 9 | Налайх дүүргийн ОБХ | 1 | 0.0 | | | | | | | 1 | 0.0 |
| 10 | Чингэлтэй дүүргийн ОБХ | 1 | 0.0 | | | | | | | 1 | 0.0 |
| 11 | Хан-Уул дүүргийн ОБХ | 1 | 0.0 | | | | | | | 1 | 0.0 |
| 12 | Баянхонгор аймгийн ОБГ | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 | | |
| 13 | Булган аймгийн ОБГ | 1 | 0.0 | | | | | | | 1 | 0.0 |
| 14 | Говь-Алтай аймгийн ОБГ | 2 | 0.0 | | | | | 2 | 0.0 | | |
| 15 | Завхан аймгийн ОБГ | 2 | 129,000.0 | | | | | 1 | 29,000.0 | 1 | 0.0 |
| 16 | Орхон аймгийн ОБГ | 1 | 0.0 | | | | | | | 1 | 0.0 |
| 17 | Өмнөговь аймгийн ОБГ | 2 | 2,716,620.3 | | | | | 2 | 2,716,620.3 | | |
| 18 | Сэлэнгэ аймгийн ОБГ | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 | | |
| 19 | Ховд аймгийн ОБГ | 2 | 0.0 | | | | | | | 2 | 0.0 |
| **Нийт дүн** | | **24** | **3,978,747.6** | **-** | **-** | **-** | **-** | **9** | **2,859,620.3** | **15** | **1,119,127.3** |